



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 1574

Мандалговь

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3.1.д, 3.2.6.а дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 21'367'500 /хорин нэгэн сая гурван зуун жаран долоон мянга таван зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, 6'410'300 /зургаан сая дөрвөн зуун арван мянга гурван зуу/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй, 39-85 ДУА улсын дугаартай Тоёото Прадо маркийн автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Автомашиныг худалдах үнийн доод хязгаарыг 6'000'000 /зургаан сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.
3. Худалдсан тээврийн хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн бүртгэлээс хасахыг Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын дарга Ю. Дашдаваад даалгасугай.

ДАРГА

С.БУДЖАВ

